

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХҮСЭЛТЭЙ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН УРИЛГА  
ЗЗБУХНСТ2019/05

2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

Нэгдсэн үндэстний байгууллагын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн зээлийн хөрөнгөөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Архангай, Дорнод, Өвөрхангай, Хэнтий аймгуудад хэрэгжүүлж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” нэмэлт санхүүжилт төслийн хүрээнд “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө”-г шинээр боловсруулах болон өмнө нь хийгдсэн төлөвлөгөөнд тодотгол хийх чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагуудыг сонгон шалгаруулах тендерт мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Зөвлөх үйлчилгээ нь 4 багцтай байна. Үүнд:

**Багц 1.** Архангай аймгийн Хайрхан, Төвшрүүлэх суманд нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө шинээр боловсруулах, Архангай аймгийн Эрдэнэмандал суманд өмнө хийгдсэн нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд тодотгол хийх ЗЗБУХНСТ2019/05/01 дугаартай тендер,

**Багц 2.** Өвөрхангай аймгийн Хархорин, Тарагт, Төгрөг суманд нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө шинээр боловсруулах ЗЗБУХНСТ2019/05/02 дугаартай тендер,

**Багц 3.** Хэнтий аймгийн Өмнөдэлгэр суманд нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө шинээр боловсруулах, Хэнтий аймгийн Батширээт суманд өмнө хийгдсэн нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд тодотгол хийх ЗЗБУХНСТ2019/05/03 дугаартай тендер,

**Багц 4.** Дорнод аймгийн Сэргэлэн, Халхгол, Хөлөнбуйр суманд нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө шинээр боловсруулах ЗЗБУХНСТ2019/05/04 дугаартай тендер.

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээллүүдийг ирүүлнэ. Үүнд:

- Байгууллагын товч танилцуулга;
- Сүүлийн 5 жил /2013-2018 оны /-ийн хугацаанд боловсруулсан 2 /хоёр/-оос доошгүй газар зохион байгуулалтын төлөвлөгөөний баримт бичгийн жагсаалт, тэдгээрийн өртөг, хугацаа, байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт;
- Хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- “Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх” тусгай зөвшөөрлийн хуулбар (тусгай зөвшөөрлийн хугацаа 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүчинтэй байх);
- Аж ахуйн нэгж, байгууллагын үндсэн болон гэрээт мэргэжилтнүүдийн боловсрол, мэргэжлийн ур чадварыг харуулсан нотлох баримт (Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай эрхтэй аж ахуй нэгжийн голлох мэргэжилтнүүдийн аль нэг нь бэлчээр ашиглалтын судалгаа, иргэд, олон нийтийн оролцоотой бэлчээрийн менежментийн төлөвлөгөө хийж байсан туршлагатай, малчид иргэдтэй харилцах, иргэдээс судалгаа, санал асуулга авах үр дүнг нэгтгэх, тайлагнах, хэлэлцүүлэг зохион байгуулах чадвартай байх);
- Багаж, тоног төхөөрөмжийн жагсаалт;
- Ажлын байртайг нотлох баримт /үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар эсвэл 2019 оны түрээсийн гэрээ/;
- Санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан сүүлийн 2 жил /2017-2018 оны/-ийн эцсийн санхүүгийн тайлан;
- “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан холбогдох шаардлагуудыг хангаж байгааг нотолсон баримт бичгүүд. Үүнд:
  - o Төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсвэл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байдал үүсээгүйг нотлох харьяалах Шүүх /Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон Шүүхийн төрөлжсөн архив/ болон Улсын ерөнхий бүртгэлийн газрын лавлагаа;
  - o Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй нөхцөл байдал үүсээгүйг нотлох харьяалах татварын газрын тодорхойлолт
  - o Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн өргүй болохыг нотолсон тухай холбогдох байгууллагын тодорхойлолт;
  - o Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулагдахгүй тухай тендер оролцогчийн албан бичиг болон хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээ;
  - o Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон нөхцөл байдал үүсээгүйг нотлох Шүүхийн тодорхойлолт болон тендер оролцогчийн албан бичиг;
  - o Тендер оролцогч нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхол үүсээгүй тухай тендер оролцогчийн албан бичиг;
  - o Худал мэдээлэл бүхий тендер ирүүлээгүй тухай тендер оролцогчийн албан бичиг;
  - o Сүүлийн 3 жилийн хугацаанд Авилгын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авилгын, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сурдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон болохыг шүүх тогтоосон нөхцөл байдал үүсээгүйг нотлох Шүүхийн тодорхойлолт.

Тендер шалгаруулалтыг хосолмол үнэлгээний аргаар хоёр үе шаттай дүгнэнэ.

Ерөнхий шаардлага хангаж хураангуй жагсаалтад орсон мэргэжлийн байгууллагуудыг тендерийн техникийн болон санхүүгийн саналаа ирүүлэх дараагийн шатны тендерт урих ба тендерийн материалыг эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 /Тавин мянга/ төгрөгөөр худалдана. Данс: Төрийн сан-100900011865. Хүлээн авагчийн нэр: ЗЗ ба БУХөгжил төсөл-Н.С.

Хураангуй жагсаалтад ороогүй мэргэжлийн байгууллагуудын материалыг эргүүлэн олгохгүй болно.

Тендер оролцогч нь холбогдох материалыг битүүмжилж 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 12 цаг 00 минутаас цагаас өмнө дор дурдсан хаягаар ирүүлнэ үү.

Хаяг: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө-16/А, Засгийн газрын 9/А дугаар байр, 6 дугаар давхар, 605 тоот өрөө

Нэмэлт мэдээллийг дараах утсаар авч болно. Утас: 77115010, 77115040; Факс: 77115060